



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 12 сарын 24 өдөр

Дугаар 90

Мөрөн

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 7.4 дахь заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь**

1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж, архидан согтуурахтай тэмцэх зорилгоор "Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох журам"-ыг хавсралтаар баталж, 2016 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2. Журам батлагдсантай холбогдуулан 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө олгосон согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахдаа журмын нэг дэх хэсгийг баримталж, шинээр олгохдоо журмыг хэрэгжүүлж худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон цэгийн тоо нормативт нийцүүлэх арга хэмжээг авч, цагийн хуваарийг өвөл, зуны байдлаар тогтоон мөрдүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга /А.Эрдэнэбаатар/- т даалгасугай.

3. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх үйл ажиллагаа явуулсан тухайн жилийн борлуулалтын орлогын нэгээс доошгүй хувийг архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх, нийгмийн сайн сайхны төлөө зарцуулахад зориулахыг тусгай зөвшөөрөл эзэмшигчидэд уриалсугай.

4. Журмын хэрэгжилтэд байнгын хяналт тавьж хариуцлага тооцон ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтсийн дарга /Г.Гандэлгэр/-д Мэргэжлийн Хяналтын газрын дарга /Ж.Даваахүү/-д, Цагдаагийн газрын дарга /Н.Батбаяр/-д тус тус үүрэг болгосугай.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдааны 2009 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн "Журам батлах тухай" 36 дугаар тогтоол, 2008 оны "Уриалга дэмжих тухай" 26 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болгосугай.

ДАРГА

(Handwritten signature)

Т. БОЛДБААТАР

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2015 оны 12 дугаар сарын
24-ний өдрийн 90 дүгээр тогтоолын хавсралт

СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДААЛАХ ТҮҮГЭЭР ҮЙЛЧЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, СУНГАХ, ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ЖУРАМ

Нийтлэг үндэслэл

Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох үйл ажиллагаа, /цаашид тусгай зөвшөөрөл гэнэ/ тусгай зөвшөөрлийг олгох, сунгахад бүрдүүлэх материал, аж ахуйн нэгж, иргэнд тавигдах шаардлага, хүлээх үүрэг, хориглох зүйл, тавих хяналт, хүлээлгэх хариуцлагын талаар зохицуулахад энэхүү журмын зорилго оршино

Нэг. Тусгай зөвшөөрөл олгох

1.1. Согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг аж ахуйн нэгж /хуулийн этгээд/, татвар төлөгчөөр бүртгэлтэй иргэнд сонгон шалгаруулалт явуулж аймгийн Засаг даргын захирамжаар олгоно.

1.2 Сумын Засаг даргын шийдвэрээр томилогдсон 5 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг сонгон шалгаруулалтыг явуулж, дүгнэлт гаргана. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд сумын Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч, Татварын байцаагч, Цагдаагийн алба хаагч, ЗДТГ-ын дотоод ажил, эрх зүйн сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн, ИТХ-ын нарийн бичгийн дарга байна.

1.3. Ажлын байрны шаардлагын болон техникийн нөхцлийн үзүүлэлтийг 100 хувь хангаж байгаа аж ахуйн нэгж, иргэнийг шалгаруулна.

1.4. Сонгон шалгаруулалтын талаар маргаан үүссэн болон шаардлагатай бол аймгийн Засаг даргын шийдвэрээр томилогдсон ажлын хэсэг газар дээр нь очиж дүгнэлтийг гаргана.

1.5. Тусгай зөвшөөрлийг олгоход бүрдүүлэх материал:

1.5.а. Сумын Засаг даргын санал

1.5.б. Аж ахуйн нэгжийн гэрчилгээ, иргэн бол иргэний үнэмлэхийн хуулбар /нотариатаар батлуулсан/

1.5.в. Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл

1.5.г. Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт явуулсан ажлын хэсгийн дүгнэлт

1.5.д. Тэмдэгтийн хураамж төлсөн баримт

1.5.е. Зөвхөн аялал жуулчлалын улиралд ажилладаг жуулчны баазуудад үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг олгохдоо Худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тогтоосон цэгийн тоо, нормативт хамааруулахгүй байж болно.

1.6. Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг явуулахдаа техникийн нөхцөлд зайлшгүй шаардлагатай дараах зүйлийг заавал тусгана.

1.6.а. Объектын гадна орчны тохижилт, /цэцэрлэгжүүлэлт, талбайн тохижилт/ тусгай гэрэлтүүлэгтэй байх

1.6.б. ААН, иргэн нь үйл ажиллагаа явуулах ажлын байрандаа барааны зураасан код унших тооцооны машинтай байх.

1.6.в. Ажлын байрны гадна талбайд тусгайлан зассан машины зогсоол явган хүний замтай байх /5м х10м багагүй хэмжээтэй/

1.6.г. Объектын гадна болон дотор талд гэрэлтүүлэггүй орчинд дүрс таних хүчин чадалтай шаардлага хангасан хяналтын камертай, 30-аас доошгүй хоног дүрс бичлэг хадгалах төхөөрөмжтэй байх

1.6.д. Өмнө нь хууль тогтоомж, худалдаа үйлчилгээний газрын стандарт, нөхцөл, шаардлагыг зөрчөөгүй, зөрчил дутагдал гаргаагүй байх

1.6.е. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх ААН, иргэний үйл ажиллагаа явуулах ажлын байр, ажиллах хүчний нөөц нь Монгол улсын "Худалдааны газрын үйлчилгээ" MNS 5021:2007, Хоолны газрын үйлчилгээ MNS 4946:2005, стандартад тавигдсан шаардлагад нийцсэн байх бөгөөд худалдаа, үйлчилгээний танхимаас гадна технологийн урсгалыг зөв тооцож шийдсэн бэлтгэлийн өрөөтэй байх.

1.6.ё. Ажлын байр нь галын аюулгүй байдлыг хангасан байх

1.7. Тусгай зөвшөөрлийг 2 жилийн хугацаагаар олгоно.

1.8. Тусгай зөвшөөрлийг олгохдоо шинэ бүтээн байгуулалт, дэвшилтэт үйлчилгээ эрхлэх, ажлын байр шинээр бий болгосон үйлчилгээг / аялал жуулчлал, зочид буудал, зоогийн газар/ дэмжиж олгоно.

1.9. Кафены ангиллаар үйл ажиллагаа эрхлэгчдэд зөвхөн дарс, шар айргаар үйлчлэх тусгай зөвшөөрөл олгоно.

1.10. Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд тусгаж өгнө.

1.11. Тусгай зөвшөөрөл олгохоос татгалзах

1.11.а. Энэ журмын 1.1-1.7-д заасан шаардлагыг хангаагүй талаар ажлын хэсгийн зохих дүгнэлт гарсан

1.11.б. ААН, иргэн нь урд өмнө нь холбогдох хууль тогтоомж, стандарт, энэхүү журмыг зөрчиж байсан

1.12. Тусгай зөвшөөрлийг олгох, сунгахад санал, дүгнэлт гаргахдаа хариуцлагагүй хандсан албан тушаалтнуудад хариуцлага тооцно

1.13. Тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох асуудлыг аймгийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтэс хариуцаж ажиллана.

Хоёр. Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах

2.1. Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийг зөрчөөгүй бол хугацааг 2 жилээр сунгах шийдвэрийг аймгийн Засаг дарга гаргана.

2.2. Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулахыг хүсэгч нь дараах материалыг бүрдүүлж хугацаа дуусахаас 14 хоногийн өмнө Сумын Засаг дарга түүний Тамгын газарт ирүүлнэ.

2.2.а. Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулах тухай өргөдөл

2.2.б. Ажлын хэсгийн дүгнэлт

2.2.в. Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт.

2.2.г. Сумын Засаг дарга саналаа холбогдох материалын хамт аймгийн Засаг даргад ирүүлнэ .

Гурав. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх.

3.1. Тусгай зөвшөөрлийн хугацаа, нөхцөл, шаардлага , энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд сумын Засаг дарга, МХГ, Цагдаагийн газар, Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн албан бичгээр гаргасан санал, дүгнэлтийг үндэслэн тусгай зөвшөөрлийг хугацаанаас өмнө түдгэлзүүлнэ.

3.2. Тусгай зөвшөөрлийн хугацаа, нөхцөл, шаардлага энэхүү журмыг зөрчсөн тохиолдлыг холбогдох байгууллага, албан тушаалтан баримтжуулж зөрчил гаргагчид танилцуулсан байвал зохино

3.3. Түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлөө арилган холбогдох байгууллагаар шалгуулсан тухай дүгнэлтийг үндэслэн тусгай зөвшөөрлийн эрхийг анх авсан зөвшөөрлийг үлдсэн хугацаагаар сэргээнэ.

Дөрөв. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох:

4.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан.

4.2. Хуулийн этгээд татан буугдсан болон худалдаа, үйлчилгээний газраа бусдад худалдсан, бэлэглэсэн, шилжүүлсэн.

4.3. Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг удаа дараа зөрчсөн /2 ба түүнээс дээш/ болон түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгах талаар эрх бүхий этгээдээс тавьсан шаардлагыг биелүүлээгүй.

4.4. Онцгой албан татварын тэмдэггүй, хуурамч тэмдэгтэй, үндсэн баримтгүй болон хуурамч баримттай худалдаа үйлчилгээ эрхлэн Татварын болон холбогдох бусад хуулийг зөрчсөн.

4.5. Зөвшөөрөл олгосноос хойш өөр газар байршлаа өөрчилсөн буюу тусгай зөвшөөрлийн эрхийг бусдад шилжүүлсэн.

4.6 Тусгай зөвшөөрөл олгосноос хойш үйл ажиллагаа эхлээгүй 3 сар болсон.


4.7.Тусгай зөвшөөрлийг авахдаа хуурамч бичиг баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон

4.8. Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн заалт бүрийг зөрчсөн болох нь тогтоогдвол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.

4.9.Тусгай зөвшөөрлийн эрхийг олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон тухай шийдвэрийг аймгийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтэс нь Сумын Засаг дарга, холбогдох байгууллага, аж ахуйн нэгжид албан бичгээр ажлын 3 хоногийн дотор хүргүүлнэ

Тав. Согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх аж ахуйн нэгж, иргэний хүлээх үүрэг

5.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь улсын бүртгэлийн гэрчилгээ, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл, бүтээгдэхүүн тус бүрийн шинжилгээний бичиг, улсын байцаагчийн дүгнэлт, бэлтгэн нийлүүлсэн газрын зарлагын баримт /тамга, гарын үсэгтэй байх/ зэрэг бичиг материалын бүрдлийг байнга ханган шаардлагатай тохиолдолд эрх бүхий этгээдэд чирэгдэлгүй шалгуулна.



5.2. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хэрэглэгчдэд харагдахуйц газар байрлуулан, аймгийн Засаг даргын баталсан цагийн хуваарийг хатуу чанд мөрдөж ажиллана.

5.3. Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр байгууллага хамт олны дунд зохион байгуулж байгаа ажил, сайн туршлагаа сурталчлах, архинаас гарсан хүмүүсийг шагнаж урамшуулахад санаачлагатай ажиллана.

5.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигчид нь албан өрөө, ажлын байр, агуулах болон үйлчилгээний танхимд согтууруулах ундаа хэрэглэхгүй улмаар хамт олноороо согтууруулах ундаа хэрэглэдэггүй, архигүй орчин бүрдүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авна.

5.5. Хууль, хяналтын байгууллага, аймаг, сумын төрийн байгууллагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь чанартай биелүүлэх, шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, иргэд үйлчлүүлэгчдээс гарсан санал, гомдлыг барагдуулахад хариуцлагатай хандаж ажиллана.

5.6. Зөвхөн стандарт, чанарын баталгаатай хүнсний бараа бүтээгдэхүүнийг хүлээн авч, зөв хадгалан боловсруулж, Монгол улсын "Төрөл бүрийн архи, техникийн ерөнхий шаардлага" MNS179:2009 стандартад нийцсэн согтууруулах ундаагаар худалдаалж, үйлчилнэ.

5.7. Зоогийн газар, баар, кафе нь үйлчилгээнд шаардагдах цэвэр үзэмжтэй хийгдсэн хоолны цэстэй байна.

5.8. Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, иргэн нь архины талаарх хориглосон болон далд сурталчилгааг явуулахыг хатуу хориглох бөгөөд Зар сурталчилгааны тухай болон Өрсөлдөөний хуулийг чанд баримтлана.

5.9. Суурилуулсан камерийг байнгын ажиллагаатай байлгах бөгөөд бичлэгийг устгахдаа Цагдаагийн байгууллагад мэдэгдэнэ.

5.10. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх аж ахуйн нэгжийн ажилтан нь мэргэжлийн үнэмлэхтэй, тогтмол хугацаанд эмнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамрагдана.

Зургаа. Хориглох зүйл

6.1. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээг ашиглан зөвшөөрөгдсөн байршлаас буюу тухайн байр /танхим/-аас бусад газарт согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх.

6.2. Тусгай зөвшөөрлийн эрхийг бусдад худалдах, түрээслүүлэх, гэрчилгээг хувилж олшруулах, өөр ажлын байранд шилжүүлэх, бусдад ашиглуулах.

6.3. Худалдааны газарт согтууруулах ундааг савлах, аягалж хундагалж худалдах.

6.4. Зоогийн газар, баар, кафед халуун хоол, хүйтэн зуушгүйгээр согтууруулах ундаагаар үйлчлэх.

6.5. Согтууруулах ундаа худалдах, тээвэрлэх, хадгалах, борлуулах түүгээр үйлчлэх ажилд 18 насанд хүрээгүй хүн авч ажиллуулах

6.6. 21 нас хүрээгүй болон согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн хүнд согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх

6.7. Хүүхдийн цэцэрлэг, бүх шатны сургууль, оюутан сурагчдын байр, Эрүүл мэндийн төв, Хүүхдийн байгууллагын байр, шатахуун түгээх станцын байр, орон сууцын суурийн давхар, түргэн үйлчилгээний цэг, мухлаг, павилон, түрээсийн



лангуу зэрэг байршилд согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчилэхийг хориглоно.

6.8. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь төрөл бүрийн сугалаа, хонжвор, аливаа хэлбэрийн урамшуулалт худалдаа, далд болон хориглосон зар сурталчилгаа явуулах /Согтууруулах ундаа, тамхи сурталчилсан зурагт хуудсаар тасаг, танхим, гудамжинд байрлуулах г.м/

6.9. Согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тогтоосон цагийн хуваарийг зөрчиж, худалдаа, үйлчилгээ явуулах.

6.10. ААН, иргэн нь аливаа албан тушаалтны албан бичиг, ам шийдвэрээр согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх үйл ажиллагаа явуулах.

6.11. Бөөний худалдааны төв нь чанар аюулгүй байдал, стандарт, тохирлын баталгаагүй, онцгой албан татварын шошиггүй согтууруулах ундаа худалдах, дагалдах, баримт бичиггүйгээр согтууруулах ундааг бөөнөөр худалдаалах

6.12. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь мэргэжлийн бус хүнээр худалдаа, үйлчилгээ эрхлүүлэх.

Долоо. Журмын хэрэгжилтэд тавих хяналт

7.1. Хөвсгөл аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч ААН, иргэний үйл ажиллагаа болон журмын хэрэгжилтэд бүх шатны Засаг дарга, МХГ, Цагдаагийн газар, ХЭАХН, аймаг, сумын Засаг даргын шийдвэрээр баталгаажсан ажлын хэсгийн гишүүд хяналт тавина.

Найм: Хүлээлгэх хариуцлага

8.1. Энэ журмыг зөрчсөн этгээдэд Захиргааны хариуцлагын тухай хууль болон Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

8.2. Энэхүү журмыг зөрчиж согтууруулах ундаа худалдсан түүгээр үйлчилсэн аж ахуйн нэгж, иргэний тусгай зөвшөөрлийг 2 жилийн хугацаагаар хүчингүй болгоно.

